



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 85 ВАГ-БНАТАГ (2018)-02-ТА. Номгон

Г Зөрчил арилгуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Баянхонгор аймгийн Замын сангийн хөрөнгийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар “Цахиур орд” ХХК-ийн гүйцэтгэсэн Эрдэнэцогт сумын Ямаан усны даваанаас сумын төв хүртэлх 8 км авто замын засварын ажлыг шалгахад замын тэмдэг, түмбийг дутуу хийсэн, ажлын гүйцэтгэлийг буруу гаргасан ба энэ талаар гүйцэтгэгч компаниас албан ёсоор тодруулга авах гэсэн боловч тайлбар ирүүлээгүй болно. Тус ажлыг баталсан аймгийн ИТХ-ын шийдвэрүүд болон зураг төсөвт тусгагдсан ажлын тоо хэмжээ зөрүүтэй байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 22-ны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.21-д заасан “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар балтагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно. Мөн журмын 5.4-д “Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч хариуцана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох

2518131

саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Нэг. Эрдэнэцогт сумын Ямаан уснаас сумын урд дэнж хүртэлх хайрган хучилттай зам засварын ажлын тоо хэмжээ, нэр, төсөв болон гүйцэтгэлийн зөрүүтэй асуудлыг холбогдох хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх.

Хоёр. Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 09 дугаар сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Засаг дарга дарга Г.Батжаргалд, ХОХБТХ-ийн дарга Д.Ихбаяр нарт хариуцуулав.

Дээрхи албан шаардлагыг барагдуулаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан заалтын дагуу холбогдох арга хэмжээг авах болно.

АЛБАН ШААРДЛАГЫГ

<p>БИЧСЭН:</p> <p>АУДИТОР <i>[Signature]</i> П.МӨНХ-ЭРДЭНЭ Б.НАРАНГЭРЭЛ</p> <p><i>[Stamp: МУХААГААР 143544, ХОХБТХ 9007423]</i></p>	<p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА <i>[Signature]</i> Г.БАТЖАРГАЛ ХОХБТХ-ИЙН ДАРГА <i>[Signature]</i> Д.ИХБАЯР</p> <p><i>[Stamp: МУХААГААР 143544, ХОХБТХ 9007423]</i></p>
---	--

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 86

Номгон

Санал хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Баянхонгор аймгийн Замын сангийн хөрөнгийн 2017 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1.Эрдэнэцогт сумын Ямаан усны даваанаас сумын урд дэнж хүртэлх хайрган хучилттай зам засварын ажлын төсвийг ХОХБТХ-ийн мэргэжилтэн зохиож, МХГ-ын улсын байцаагч хянаж баталсан нь өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргажээ.

2.Баянхонгор сумын ЗДТГ-ын гаднах явган зам тавих болон Эрдэнэцогт сумын Ямаан уснаас Хүрэмтийн гүүр хүртэлх хөрсөн замын засварын ажил дутуу, Баянхонгор аймгийн төв зам дагуух унадаг дугуйн замын ажил чанаргүй, Эрдэм ахлах сургуулийн гаднах авто зогсоолын ажил огт хийгдээгүй, үр дүн хангалтгүй байгаа нь захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.


Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, Сангийн сайд, дэд бүтцийн сайдын 2000 оны 47/61 тушаалаар батлагдсан журмын 4.5 дахь заалт “Захиалагч талын төлөөлөл, аймгийн ЗДТГ-ын болон сумын ЗДТГ-ын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн, МХГ-ын авто зам, тээвэр хариуцсан улсын байцаагч болон холбогдох эзэмшигч байгууллагын удирдлагууд тухай бүр нь гүйцэтгэж, хэрэгжилтийг хангуулж ажиллана” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2518133

Иймд Төрийн аудитын тухай хуулийн дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Төрийн аудитын тухай хуулийн 28.1-д “... гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

Нэг. ХОХБТХ-ийн мэргэжилтэн А.Дорж, МХГ-ын улсын байцаагч Д.Магвансүрэн нарт сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ авч, хэрхэн шийдвэрлэсэн тухай холбогдох баримтыг Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.13-т заасны дагуу ажлын 10 хоногийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Хоёр. Албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу шийдвэрлүүлэх болно.

АУДИТОР  П.МӨНХ-ЭРДЭНЭ
Б.НАРАНГЭРЭЛ



АЛБАН ШААРДЛАГЫГ

ЗӨВШӨӨРСӨН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА  Г.БАТЖАРГАЛ

